

Гарчиг

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилт
 - 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
 - 3.2 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
 - 3.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
 - 3.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
 - 3.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
 - 3.6 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалх ажлын тайлан
 - 3.7 2025 оны нэгдсэн төсвийн биелэлт
4. Дүгнэлт


“ИДЭР ХАЙРХАН” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Идэр хайрхан” ХХК-н үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Цохио толгой – 2 шохойн чулууны орд нь Дархан-Уул аймгаас зүүн тийш 8 км, Хонгор сумаас хойш 31 км-т Шийрийн хөндийн адагт Цохио толгойн өвөрт байрладаг.

Төслийн байршлын газар зүйн солбицол:

Зүүн уртрагийн	Хойд өргөргийн
106°02' 22"	49° 26' 05"
106°02' 22"	49° 26' 20"
106°02' 55"	49° 26' 20"
106°02' 55"	49° 26' 05"



–“Цохио толгой 2” шохойн чулууны ордын байршлын зураг.

Төслийн зорилго

Орд газраас шохойн чулууг олборлон хямд, сайн чанарын шохойн чулууг шохойн болон цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, орон нутагт тодорхой хэмжээний ажлын байр бий болгох, цаашид ордыг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах замаар ашиглалтыг нь сайжруулан ордоос олборлосон бүхнийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгож борлуулах, орд орчмын унаган төрхийг эргүүлэн сэргээх нөхөн сэргээлт хийхэд голлон анхаарах зорилт тавин ажиллаж байна.

Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл

Уул зүй: Хонгор сум нь Хангай, ойт хээрийн бүст Хараа, Ерөө голын сав газарт далайн төвшнөөс дээш 700-1000 метрт өргөгдсөн, цаг уурын эрс тэс уур амьсгалтай. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Уул нурууд нь хойноос урагш уртгаг дагасан байрлалтай байна. Сумын нутаг дэвсгэр нь уул, ой хээр, уул мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Төсөл хэрэгжих Дархан-Уул аймаг нь байгалийн бүс бүслүүрээр ойт хээрийн болон хээрийн бүсэд хамаарах бөгөөд “Шохой шатаах эргэх зуухан цех” төслийн талбай нь байгалийн бүс бүслүүрээр ойт хээрийн бүсэд хамаарч байна. Гэвч төсөл хэрэгжих талбайд ойн зурвас газар байхгүй болно. Уулын энгэрт байрлаж байна.

Цаг агаар, хур тунадас: Байгалийн эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ, чийг багатай цаг агаарын нөхцөлтэй. Тус аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд ширүүвтэр өвөлтэй, дулаан зунтай, чийгээр дутмаг мужид багтана. Хонгор сум орчмын нутгаар сүүлийн 30 жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж -1.9 градус хүйтнээс +3.2 градус дулаан байдаг байна. 1984-1988, 1991, 1996, 2005, 2010, 2012 онуудад агаарын температурын жилийн дундаж утга хасах градустай, бусад онуудад нэмэх градустай байдаг.

Агаарын температурын УАД-нь 0.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Хонгор суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Хонгор суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг.

Ус зүй: Монгол орны гадаргын усны Хойд мөсөн далайн ай савын Хараа голын ай савд хамаарна. Далайн төвшнөөс дээш 700-1000 метрт өргөгдсөн. Хэнтий нуруунаас эх авч урссан том, жижиг голууд бүрдэл нь Хараа голд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Дархан Уул аймгийн усаар бүрхэгдсэн нийт талбай 2112.54 га. Үүнээс гол горхи 1998.0 га, нуур цөөрөм 24.0 га, үйлдвэрийн болон аж ахуйн зориулалтын усан сангийн талбай 1.0 га тус тус эзэлдэг. Гадаргын усны бүртгэл тооллогоор уст цэг 956, нуур цөөрөм 3, гол горхи 31, булаг шанд 26, худаг 878 бүртгэгджээ.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Дархан-Уул аймгийн Хонгор сум нь Буурал, Зулзага, Салхит гэсэн 3 багийн нийт 1529 өрхөд 5694 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Дархан-Уул аймгийн 4 сумаас 3-т, аймгийн газар нутгийн 77 хувийг эзлэн оршдог, хүн амын нягтрал

нь 46,35хүн/га. Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэлтэй холбосон улсын чанартай 34 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог бөгөөд 2021 онд Салхит багийг сумын төвтэй холбодог замыг хатуу хучилттай болгосон байна. Монголын газар тариалангийн төв бүсэд оршдог учраас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд газар тариалан голлодог бөгөөд газар тариалангийн аж ахуйнууд шинжлэх ухааны баазтайгаа ойрхон байрлаж, түүнтэй хамтран ажилладгаараа бусад аймгуудаас давуутай юм. Аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амын мах махан бүтээгдэхүүний хэрэгцээний 30%, сүү сүүн бүтээгдэхүүний 90%, гурил гурилан бүтээгдэхүүний 70% гаруй хувийг, төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа стратегийн ач холбогдол бүхий салбарын нэг юм.

Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл Агаар мандал

Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ

MNS6063:20108, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS4585:2007

Сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалт, дайрга үйлдвэрлэлт, тээвэрлэлтийн үед тоос босож агаарыг бохирдуулж болзошгүй.
- Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчныг хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.
- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэцтэй холбоотойгоор газар овоолгод дарагдах зэргээр эвдрэлд орно.

Ус, усан орчин

Усны тухай хууль, Хаягдал бохир ус MNS4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам.

Сөрөг нөлөөлөл:

- Түлш шатахуун, тослох материалууд бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах, асгарах зэргээс үүдэн бага гүнд орших уст давхарга болон гадаргын усыг бохирдуулж болзошгүй.

- Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлаа зөв менежмент явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус бактери болон химийн бохирдолд орж болзошгүй.

Хөрс, ургамал, газар

Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Ургамал хамгааллын тухай, Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS5914:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5915:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5916:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008, Байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2008.

Сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэцтэй холбоотойгоор газар овоолгод дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх.
- Орд орчмын байгалийн гадаад үзэмж муудаж болзошгүй.
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2025 оны Уулын ажлын тайлан

“Цохио толгой 2” шохойн чулууны уурхай нь 2025 онд 2024 оны уулын ажлыг цааш үргэлжлүүлэн явуулсан. Ингэхдээ уурхай 45м гүнд буюу +755м-ийн түвшин хүртэл, давхаргын суналд хөндлөн чиглэлээр уулын ажлыг явуулсан. Уурхайн урт 350 м, дунджаар өргөн 160 м, уурхай нийт 5.5 га талбайг эзэлж байна. “Цохио толгой 2” ордоос 2025 онд 28.75 мян.м³ хөрс хуулж, 35.9 мян.тн шохойн чулуу, 20.26 мян.м³ дайрга гарган борлуулсан байна.

Уурхайн ажиллах горим. “Цохиот толгой – 2” уурхайн 2025 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээг үндэслэн жилийн турш тасралтгүй ажиллана. Уурхайн ажлын горимыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Сарууд	Календарь хоног	Амралтын өдөр	Ажиллах хоног	Ажиллах ээлжийн тоо	Ажиллах хугацаа, цаг
1	31	9	22	1	176
2	28	8	20	1	160
3	31	10	21	1	168
4	30	8	22	1	176
5	31	9	22	1	176
6	30	9	21	1	168
7	31	13	18	1	144
8	31	10	21	1	168
9	30	8	22	1	176
10	31	8	23	1	184
11	30	10	20	1	160
12	31	9	22	1	176
Жилд	365	111	254	1	2032

Хөрс хуулалтын ажил. Цохио толгой – 2 уурхайн үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь VIII-X зэрэглэлд хамаарагдаж байгаа нь хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг-тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийж шилжүүлэх шаардлагатай. Хөрсний чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа экскаватороор автосамосвалд ачин ил уурхайн гадна байрлах гадаад овоолгын талбайд байрлуулж, хөрс хуулалтын ажилд 1.2 м³-ын утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик экскаватораар ажлыг хийж гүйцэтгэлээ.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2. Уурхайн 2025 оны уулын ажил

№	Үзүүлэлтүүд		2025 онд ажилласан улирал				Нийт
			I-р улирал	II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	7.5	12.6	11.9	10.7	42.582
2	Хөрс хуулалт	мян.м ³	4.3	8.9	8.8	6.8	28.750
		мян.тн	9.89	20.47	20.13	15.64	66.1
3	Шохойн чулуу олборлолт	мян.м ³	3.2	3.7	3.1	3.9	13.83
		мян.тн	8.23	9.54	8.07	10.12	35.96
4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	3.13	5.58	6.48	4.02	4.78
		м ³ /тн	1.20	2.15	2.49	1.54	1.84

Өрөмдлөг-Тэсэлгээний

“Монмаг” ХХК –тай гэрээгээр хамтран ажиллаж тэсэлгээний ажлыг энэ онд 5 удаа хийсэн бөгөөд 2025оны төлөвлөгөөгөөр 46.1мян.м³ уулын цул тэслэхээс 42.6мян.м³ уулын цул тэсэлж, нийт 7923 тууш метр өрөмдлөг хийж, 41.7 тн бодис хэрэглэсэн байна.

Хөрс, тээвэрлэлт:

Дөрөвдөгчийн хурдсыг эксковатораар шууд утган автосамосвалд ачиж үржил шимт хөрсний овоолгын талбайд тээвэрлэж, үндсэн чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлсний дараа гадаад овоолгын талбайд шилжүүлсэн. Хөрсний тээврийн зай дунджаар 400м ба дөрөвдөгч хурдаснаас үржил шимт хөрсийг хуулан уурхайн зүүн талд байрлах хуучин шимт хөрсний овоолго дээр нэмж өгсөн.

Шохойн чулуу тээвэрлэлт:

Шохойн чулууг мөн өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлсний дараа шохойн чулууг түр овоолго руу 1.2км зайд Nowo маркийн автосамосвал ашиглан тээвэрлэж бутлуурт өгдөг. Бутлуураас гарсан шохойн түүхий эд болох буталсан шохойн чулууг агуулах руу тээвэрлэдэг.

Байгаль орчны менежмент

Ордыг ил уурхайгаар ашиглах нөхцөлд ил уурхай, гадаад овоолго, үйлдвэрийн барилга байгууламж авто зам, уурхайн тосгон зэрэгт зориулсан 8.9 га эдэлбэр газар, талбайн гадаргуу өртөгдөж байна. Үүний 8.6 га талбай нь 2024 оны эцэст эвдрэлд орсон байсан бөгөөд энэ онд нэмж 0.3га талбай уулын ажилд өртөж байгаа.

Эдэлбэр газруудыг зөв ашиглан байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах ажлыг уурхай барьж байгуулсан цагаас эхлэн байгаль орчныг хамгаалах болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зорилгыг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган батлуулж гүйцэтгэлийг дүгнүүлж явдаг. Байгаль орчноо хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын ажилчдад 9 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн орон нутгийн оролцоог идэвхжүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын ажилтнуудаас заавар зөвлөгөөг авч ажиллаа. 2025 онд 8 чиглэлээр ажлуудыг хийхээр төлөвлөсөн.

Төлөвлөгөөнд тусгасан ажлуудын биелэлтийн тайлан

1. Уурхайг тойрсон хашааг засаж сэлбэх, шинээр мод тарьсан талбай болон энэ онд мод тарих талбайг хашаажуулж хамгаалах ажлыг хийсэн.



2. Уурхайн засварын хэсгээс бусад газарт засвар хийх улмаар шатах тослох материал асгарч орчныг бохирдуулах зөвшөөрөгдсөн бүсээс бусад хэсэгт тээврийн хэрэгслийн хог хаягдлыг хаяхгүй байх, хөрс хуулалт болон технологийн техник зорчих хэсгийг авто зам, ажлын тавцан мөргөцгийн тоос, шороог багасгах зорилгоор зориулалтын бус зам гаргахгүй байх мөн орчны тоосыг багасгахаар усалгааг тогтмол хийсэн.



Ажилласан тос маслыг тоног төхөөрөмжийн тосолгоонд хэрэглэх, тос болон маслоны шүүрийг зориулалтын засварын төвд солих, асгарсан хэсгийг элс шороогоор дарж цэвэрлэх ажлыг мөн зохион байгуулсан.





3. Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байна.



4. Хог хаягдлын менежментийг дараахь байдлаар хэрэгжүүлэн ажиллалаа.

❖ Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгүүлэн дугаар авч аюултай хог хаягдлын тайлан өгч ажилласан.

❖ Ахуйн шингэн хаягдлаа тусгай цооногт төвлөрүүлэн бохир ус соруулан зайлуулах ажлыг сард нэг удаа тусгай зөвшөөрөл бүхий эрхтэй “Марз Зүрх Хайрхан” ХХК-тай гэрээ байгуулан 3 дахь жилдээ хамтран ажиллаж байна.




❖ Уурхайн засварын цехээс гарсан ашигласан тос маслыг Тулгат шийр ХХК-ийн эргэх зуухны булын тосолгоонд хэрэглэсэн.



❖ Зуны улиралд гал тогоо, ажилчдын байр, орчин тойрны хогийн саванд хортон шавж, халдваргүйжүүлэлтийн ариутгалыг хийлгэж, ариутгах микробиологийн бэлдмэлээр уусмал бэлтгэн 04, 11-р саруудад ахуйн орчинд цацсан.





- ❖ Хатуу болон, хортой хог хаягдлыг цуглуулах ангилал бүхий хогийн саванд хуримтлуулан хатуу хог хаягдлыг Дархан-Уул аймгийн Хонгор сумтай гэрээ байгуулан гэрээний дагуу сард 1 удаа хогийн цэг рүү ачуулж байна. Хортой хог хаягдал бүхий аккумулятор маслоны шүүр, сав зэргийг Үлэмж хүдэр ХХК-тай байгуулсан гэрээний дагуу аюултай хог хаягдлыг дагалдах хуудасны дагуу хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.



Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНБААТУГ-ын дарга
(Д.Армунболд)



БАТЛАВ:
Д.Армунболд

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ
ТЗӨВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 08 сарын 16 ны өдөр № Хонгор сум

Энэхүү гэрээг нэг талаас хуулийн этгээдийн 279902 улсын бүртгэлийн дугаар 4283754 репестрийн дугаартай Дархан-Уул аймаг Хонгор сум "Хонгор Хот Тохижилт" ОНБААТУГ (цаашид үйлчлэгч) тал гэх түүнийг төлөөлж Хог хаягдлын үйлчилгээний зохион байгуулагч Гансүх овогтой Нарантуяа нөгөө талаас хуулийн этгээдийн 191018109 улсын бүртгэлийн дугаар 4283754 репестрийн дугаартай А.Баттулга нэвчлэн авч үйлчлэгч түүнийг төлөөлж Б.Мөнхжаргал нэвчлэн авч (цаашид "Албан тушаалтай" тал гэх нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмыг удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл

1.1. Дархан-Уул аймаг Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНБААТУГ нь Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, бутлж устгах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагааны үндсэн чиглэл, хог хаягдлыг тухай хуулийн хүрээнд захиалагч ахуйн хог хаягдлыг хувиарын дагуу татан зайлуулах.

1.2. Захиалагч тал хогоо тээвэрлүүлэхээр дуудлага өгсөн тохиолдолд "Хонгор хот тохижилт" ОНБААТУГ ариулалтын тээврийн хэрэгсэлээр захиалагчийн хог хаягдлыг татан зайлуулах.

1.3. Гэрээг 3 жилийн хугацаатай байгуулж сунгалт хийх, нэмэлт өөрчлөлт оруулах зарчмаар хэрэгжүүлэх ба хоёр тал тус бүр нэг хувийг хадгална.

Хоёр: Үйлчилгээний эрх, үүрэг.

2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, бутлж устгах эрх бүхий "Хонгор Хот Тохижилт" ОНБААТУГ-тай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

2.2. Шаардлага хангасан хогийн савтай байх, хог хаягдлыг ачих нөхцөл боломжоор хангасан байх

2.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд Хонгор сумын "Хонгор Хот Тохижилт" ОНБААТУГ-ын Хаан банкны 5054187159 тоот дансанд төлөх.

2.4. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, зохион байгуулалттай үйл ажиллагаанд



БАТЛАВ:
"ҮЛЭМЖ ХҮДЭР" ХХК
ЗАХИРАЛ А.БАТТУЛГА



БАТЛАВ:
"ИДЭР ХАЙРХАН" ХХК
ЗАХИРАЛ Б.МӨНХЖАРГАЛ

❖ Хатуу хог хаягдлыг хог тээвэрлэлтийн газарт ачуулж, хог тээвэрлэлтийн газар ачаалал ихтэй үед өөрсдийн тээврээр хогны цэгт хүргэх ажлыг зохион байгуулсан. Хонгор сумаас өгсөн үүрэг даалгаврын дагуу үйлдвэрийн ойр орчмын талбай болон карьер орчмын айлуудын хогийг цэвэрлэн ачилт хийсэн бөгөөд нийт 2км орчим талбайн хогийг цэвэрлэн ажилласан. Мөн ойр орчмын иргэд хогоо хогийн цэг рүү хаяхгүй жалганд хаяж байсан тул өөрсдийн техникийг ашиглан жалгыг битүүлэх ажлыг хийж гүйцэтгэв.





5. Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй хэсэгт галын хор байршуулж, тэмдэг тэмдэглэгээ хаалт хашлагыг сайжруулан засаж сэлбэж мөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны самбарууд болон сургалтуудыг гаднын байгууллагаар болон дотооддоо зохион байгуулан ажиллаа. Нийт 19 ширхэг галын хор байрлуулан тогтмол шалгалт хийж бүртгэл хөтөлж байна.



**“Цохио толгой-II” шохойн чулууны орд 2025 оны байгаль орчны
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 онд ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон ажилчдыг идэвхжүүлэх, байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулах чиглэлүүдээр сургалтуудыг Дархан-Уул аймгийн Цээнэ эмнэлэг, Ойгон нөмрөн ТББ, Гэрэлт эрдэм цацрах НҮТББ, Хонгор Сумын эмнэлэг болон Онцгой байдлын газруудтай хамтран ажиллалаа.







Дархан-Уул аймгийн Цээнэ клиниктэй 4 дэх жилдээ хамтран ажиллаж нийт ажилчдыг 13 төрлийн шинжилгээ үзлэг оношилгоонд хамруулж ажилласан бөгөөд дүгнэлтээр нарийвчлан үзүүлэх шаардлагатай ажилчдыг дараачийн шатны эмнэлэгт үзүүлэх арга хэмжээг авч ажилласан.





6. Уурхайд тоос шороо босохоос сэргийлэх мөн эрүүл ахуйн таатай орчин бүрдүүлэх, ногоон байгууламж үүсгэх зорилгоор 2025 онд уурхайн засварын хэсэг, технологийн замын ойр орчмын 0.4га талбайд замын усалгааг тогтмол хийж тоос шороо босохоос сэргийлэн ашиглалтын замыг 10-20мм дайргаар хучиж зам хашлага хашааг сэргээн засав.





7. Уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа авто замын зогсоол, машин зам дагасан хэсэгт биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэв. 2025 онд нийт үйл ажиллагаа явуулж буй газарт 300ш мод тарих, шинэ болон хуучин хашааг шинээр барих сэргээх ажлуудыг төлөвлөсөн бөгөөд бид энэ онд шинэ байршилд Бадрах дэлгэр ХХК-с 300ш 4-5 наст агч мод тарьж ургуулж хуучин сэлбэх боломжтой хашааг сэргээж шинээр мөн хашаа босгов.











8. Уурхайн эзэмшлийн газар нутагт нийт төлөвлөсний дагуу 0.4 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж, тухайн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд өнжмөл бууц асган тэгшилж орон нутагт хүлээлгэн өгөв.



Эвдрэлд орсон газар-1 нөхөн сэргээлт хийхээс өмнөх зураг.





Нөхөн сэргээлт хийсний дараах зураг





Нөхөн сэргээлт хийсэн газраа өнжмөл бууц дэвсэв.



Эвдрэлд орсон газар-2 Нөхөн сэргээлт хийхээс өмнөх зураг





Эвдрэлд орсон газар-2 Техникийн нөхөн сэргээлт хийсний дараахь зураг.

Бусад ажил

Нийгмийн хариуцлагын хүрээнд:

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх өсвөрийн Хоккейн клубтэй 3 дахь жилдээ хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ жил хоккейн клубийн дээврийн засварын ажилд оролцсон ба тэмцээн уралдаанд шаардлагатай 7.5 сая төгрөгийн тусламж дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нийтийг хамарсан үйл ажиллагаанд нийт 10.000.000/арван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан ба Хонгор сумын 50 ахмадад хүндэтгэл үзүүлэн цагаан сарын тавгийн идээ өгсөн. Мөн 50 хүүхдэд гарын бэлэг өгч ажиллаа.





Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын хөрс хуулалт, элс олборлолт, тээвэрлэлтийн үед 24,1тн тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар тооцоо гарсан. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгох бөгөөд энэ жил нийт 15,03 тн хорт бодис ялгаруулахаар байна.

2025 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан техникүүд:

1. Өрөм СБУ-100 1ш
2. Самосвал Хово-336 2ш
3. Экскаватор Hyundai R2900 LC-1ш
4. Экскаватор Hyundai R290 -1ш
5. Утгуурт ачигч LIUGONG ZL-50- 2ш

Дээрх тоног төхөөрөмж ажиллуулахад цагт 176 буюу нэг ээлждээ 1408л дизелийн түлш хэрэглэнэ. 2025 онд ялгаруулах нийт хорт хийн хэмжээ нь 32.5 тн байна.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж

болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Унд ахуйн усан хангамжид нийт 980 м³ ус хэрэглэхээр 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан.

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлийг бууруулж хэрэглэсэн тос маслыг Эргэх зуухын тосолгоонд хэрэглэж хаягдалгүй болгож шийдвэрлэсэн.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж

болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 оны уулын ажлаар нийт 0.3 га талбай олборлолтод өртөж. Ордын уул геологийн тогтцоос хамааран дотоод овоолго хийх боломжгүй тул гадаад овоолготой, тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулж байна.

Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна.

Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга

хэмжээний хүрээнд:

а) Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл Самосвал Хово-336-2ш, Экскаватор Hyundai R- 2900 LC, Hyundai R290, Утгуурт ачигч LIULONG ZL50 техникүүдийн 250мөт/цаг тутамд тос масло, маслын шүүрийг тухай бүр сольсон.

б) Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услаж төсөвлөсөн 1.492.560 төгрөг зарцууллаа.

с) Уулын ажилд хамрагдах 7 тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөрийг цаг тухайд төлсөн.

Хог хаягдлын менежмент.

Бохир усны хаягдлыг “Марз Зүрх Хайрхан” ХХК-тай гэрээ байгуулан сар бүр соруулж бохир усны нэгдсэн төв шугамд хаядаг, хатуу хог хаягдлыг ангилж цуглуулан Дархан Уул аймгийн Хонгор сумтай гэрээ байгуулан хамтарч ажиллаж байна.

Нөхөн сэргээлтийн биелэлт

2025 онд манай компани техникийн нөхөн сэргээлтийг 0.4га-д, биологийн нөхөн сэргээлтийг 0.3 га талбайд тус тус хийсэн. Уурхайн ашиглалтын талбайд 300ш 4-5 наст агч мод тарьж ургуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дархан-Уул аймгийн Байгаль орчны газартай хамтран Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг Зулзагын голд Нарсан ойг нэмэх төсөл ажилд манай байгууллагын зүгээс гүйцэтгэгч Бадрах Дэлгэр ХХК-аар тариулан 10сая төгрөгийн хөрөнгө мөнгө гарган ажилласан.

**Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга
хэмжээний биелэлт**

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9.0%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргээлтийг эрчимжүүлнэ гэсэн зорилгын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сум 2-р багийн нутаг Зулзагын голд Нарсан ойг тэлэх ойжуулалтын ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хашаажуулсан 22,5га талбайд нарс тарих ажлыг сум орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран Бадрах дэлгэр ХХК-аар нарс мод тариулж арчлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн, үр дүнд ургамлын амьдралт 85%-тай жилийн өсөлт 5-10см ургасан гүйцэтгэлтэй байна.

2025 онд манай байгууллага байгалийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нарс мод тариулах ажилд 10 сая төгрөг гарган ажилласан.







Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж захирал Д.Батсүрэн, гүйцэтгэх захирал Б.Мөнхжаргал нар хариуцан ажиллаа.

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээнд мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулсан мөн жил бүрийн ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дараа хамтран ажиллаж буй Дархан-Уул аймгийн Цээнэ эмнэлгээс ажилчдад зонхилж байсан өвчин эмгэгийн талаар зөвлөгөө авч мөн эмчилгээ хийлгэх шаардлагатай ажилчдыг эмнэлэгт гадуур сториор эмчилгээг хийлгэсэн, ажилчдыг хөгжүүлэх идэвхижүүлэх байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор Гэрэлт Эрдэм Цацрах НҮТББ, ДУА-ийн Онцгой байдал, Хонгор сумын эрүүл мэндийн газар үйлдвэрлэлийн аваар ослоос урьдчилан сэргийлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг Ойгон нөмрөг ТББ сургалтын төвтэй хамтран Дархан-Уул аймгийн хөдөлмөрийн болон эрүүл ахуйн улсын байцаагч нарыг хамруулсан тус тус сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтын үйл ажиллагааны зардалд нийт 3.500.000төгрөг зарцуулсан.

Орчны хяналт шинжилгээ

Агаар

Агаарын тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн шаардлага MNS 4585:2016 баримт бичгийг удирдлага болгон агаарын шинжилгээг хийлгэсэн. Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж азотын давхар исэл NO_2 200мкг/м^3 байхаас 29мкг/м^3 , хүхэрлэг хий SO_2 450мкг/м^3 байхаас 12мкг/м^3 нийт тоосонцор 500мкг/м^3 байхаас 102мкг/м^3 гэсэн үзүүлэлттэй байна.

Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Овоолгын бүтцийн зүй зохистой төлөвлөлт нь хүчтэй салхи шуурганы үед босох тоосыг тодорхой хэмжээгээр багасгахад нөлөөлсөн.
2. Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их болдог газруудыг усалгааны машинаар тогтмол усалж байсан.
3. Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж, хурдны хязгаар тогтоож ажилласан.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ**

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-laboratory@yahoo.com

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№: 2025/1-06
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас: “ИДЭРХАЙРХАН” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Б.Үүрийнтуяа, БОШЛ-ийн ахлах шинжлэн
Сорьцын тоо, төрөл: 2 цэг, агаарын бохирдлын шинжилгээ
Сорьц авсан огноо: 2025.04.17
Шинжилсэн огноо: 2025.04.18
Хуудасны тоо: 1/3

№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжээ нэгж	MNS 4565:2016 1 удаагийн сорьцон ХА	Хэмжилт хийсэн цаг 20 минутын сорьцон дундаж агууламж /дөвтөмж/	
					1013240501	1013240502
1	MNS 0017-2-5-12:2021	Хүхэрлэг хий /SO ₂ /	мкг/м ³	450	8	12
2	MNS 0017-2-5-11:2021	Азотын давхар исэл /NO ₂ /	мкг/м ³	200	24	25
3	MNS4048-88	Нийт тоос /20 мин/	мкг/м ³	500	68	102

Товчилсон үг: ХА-хүлцэх агууламж
Сорьцын код: 1013240501- Нойтон боловсруулах цехийн орчин
1013240502- Түүхий эд буулгах талбайн орчин

Тайлбар:

- 1) Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцлийн хувьд агаарын чийгшил 18%, агаарын температур 11.8-12.7 градус дулаан, баруун өмнө, өмнийн зүүн өмнөөсөө 2-3 м/с хурдтай байсан.
- 2) Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж агаарын чанарын MNS4565:2016 стандартын 1 удаагийн сорьцон ХА-аас давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ШИНЖЭЭЧ
ХЯНАСАН
БОШЛ-ИЙН ХЯНАЛТЫН ШИНЖЭЭЧ
БАТАЛГААЖУУЛСАН:
УОШХ-ИЙН ДАРГА

Ө.АЛТАНЗУЛ
Э.САЙНЗАЯА
М.АЛИМАА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамарна

Ус

Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/A/171 тоот тушаалын 2-р хавсралт зэрэг баримт бичгүүдийг удирдлага болгон Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO₄, NO₂, NO₃, CO₃, HCO₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээг (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар) өгсөн.

Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажилласан.
2. Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаяж ачуулсан.
3. Байгууллагын ажилчдад усыг ариг гамтай хэрэглэх талаархи сургалтыг орсон.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaguur@yahoo.com



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2025/2-30
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ИДЭРХАЙРХАН” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ө Алтанзул, БОШЛ-ийн усны химийн ахлах инженер
Сорьцын тоо, төрөл : 1 цэг, усны химийн шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.09.24
Шинжилсэн огноо : 2025.09.25-2025.10.13
Хуудасны тоо : 2/3

№	Шинжилгээний аргачлал	Усны химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 0900:2018 ЗДХ	Агууламж 20691250901
1	MNS1097:2023	Ca ²⁺ /хальци/	мг/л	100.0	45.5
2	MNS1097:2023	Mg ²⁺ /магни/	мг/л	30.0	19.5
3	MNS1097:2023	Na ⁺ +K ⁺ /натри К/	мг/л	200.0	175.0
4	MNS6832:2020	HCO ₃ ⁻ /гидрокарбонат/	мг/л		468.0
5	MNS 6271:2011	SO ₄ ²⁻ /сульфат/	мг/л	500.0	44.0
6	MNS4424:2006	Cl ⁻ /хлорид/	мг/л	350.0	42.0
7	MNS1097:2023	Нийт эрдэсжилт	мг/л		760.0
8	MNS6836:2020	Нийт хатуулаг	мг-экв/л	7.0	3.21
9	MNS6779:2019	Жинлэгдэх бодис	мг/л		12.5
10	MN ISO 7150-1:2006	NH ₄ ⁺ /аммони/	мгN/л	1.5	0.18
11	MNS6779:2019	NO ₂ ⁻ /нитрит/	мгN/л	1.0	0.002
12	MNS6834:2020	NO ₃ ⁻ /нитрат/	мгN/л	50.0	0.27
13	MN ISO 6878:2001	Рэрд /ортофосфат/	мгP/л		0.034
14	MNS 6272:2011	F ⁻ /фтор/	мг/л	0.7-1.5	0.29
15	MNS 4430:2005	Fe /төмөр/	мг/л	0.30	0.010
16	MNS ISO10523:2001	РН /усны орчин/		6.5-8.5	7.68
17	MNS ISO7888:1999	ЕС /ЦДЧанар/	µS/cm		809.0
18	MNS ISO11083:2001	Cr-VI /6 валентат хром/	мг/л		илрээгүй
19	MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар	мг/л		0.7

Товчилсон үг: ЗДХ-Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дээжийн код: 20691250901- Үйлдвэрлэлийн технологийн зориулалттай худгийн ус

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН.
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР
ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР



ТАНХМАА
Э.САЙНЗАЯА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

Хөрс

MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл, MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох, MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

баримт бичгийг удирдлага болгон Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери тодорхойлуулсан шинжилгээг өгсөн.

Хөрс, ургамал, газарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө шимт хөрсийг 0.2 – 0.3м зузаантайгаар хуулж авна.
2. Уурхайн хуулж авсан өнгөн хөрсийг овоолго үүсгэлгүй Автозам засварын ажилд ачуулсан.
3. Ашигласан тос маслыг эргэх зуухны тосолгоонд хэрэглэж хаягдалгүй болгосон.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsagvund@yahoo.com



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
Сорьц авсан хүний нэр, албан тушаал

Сорьцын тоо, төрөл
Сорьц авсан огноо
Шинжилсэн огноо
Хуудасны тоо

2025/3-39
“ИДЭР ХАЙРХАН” ХХК
Ө Алтанзул, БОШЛ-ийн усны химийн ахлах инженер
2 цэг, хөрсний химийн шинжилгээ
2025.09.24
2025.10.01-12
3/3

№	Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019 ЗДХ	Тодорхойлсон агууламж	
					3069250901	3069250902
1	MNS3310:91	Хөрсний алзмаг	%		0.81	0.51
2		Нитрат, NO ₃	мг/кг	130	7.7	10.5
3		Сульфат, SO ₄	мг/кг	160	37.0	21.2
4		Аммоний, NH ₄	мг/кг		8.2	11.1
5		Фосфор, P ₂ O ₅	мг/кг		6.7	7.0
6		РН			6.08	8.27
7		ЕС	µS/cm		102.1	160.5

Товчилсон үг: ЗДХ - зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дээжийн код: 3069250901- Хуучин байуны орчин
3069250902- Уурхайн амны орчин

Тайлбар:

- 1) Хөрсний дээжийг диагоналийн арга ашиглан авч анхан шатны боловсруулт хийн шинжилгээний ажилд бэлтгэсэн.
- 2) Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат /NO₃/, сульфат /SO₄/-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ
ИНЖЕНЕР
ХЯНАН, БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР



Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний нэгдсэн төсвийн биелэлт

№	Зардлын утга	Төсөвлөсөн төг	Зарцуулсан	Зарцуулагдаагүй
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	687.000	790.000	
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал	500.000	387.000	
3	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	200.000	270.000	
4	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	450.000	460.000	
5	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	600.000	952.000	
6	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	1.280.000	2.630.000	
7	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3.000.000	10.000.000	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	748.300	951.500	
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	550.000	2.539.000	
Нийт зардлын дүн гүйцэтгэлээр		8.015.300	18.979.500	

Манай компани 2025 оны нөхөн сэргээлт, байгаль хамгаалах ажил, хяналт шинжилгээний хөтөлбөртөө нийт **8.015.300** төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **18.979.500** төгрөг зарцуулсан буюу 236.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс байгалийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардлыг тухайн жилийн байгаль орчны газраас өгөх байсан чиглэл тодорхойгүй байсан тул бид өөрсдийн зардлаар санхүүжүүлэхээр 3.000.000 төгрөг төсөвлөөд байсан. Энэхүү ажлын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дархан-Уул аймгийн Байгаль орчны газартай хамтран Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг Зулзагын голд Нарсан ойг нэмэх төсөл ажилд манай байгууллагын зүгээс гүйцэтгэгч Бадрах Дэлгэр ХХК-аар тариулан 10 сая төгрөгийн хөрөнгө мөнгө гарган ажилласан.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож **4.007.650** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны

өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан.

Хонгор сумын ЗДТГ-аас Байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах гэрээний тайланг 92% гүйцэтгэлтэйгээр дүгнүүлсэн.

Менежментийн төлөвлөгөөний биелэлт:

“Идэр Хайрхан” ХХК – ийн уурхайн 2025 оны Орчны хяналт шинжилгээний ажлыг 5, 10-р саруудад хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, агаарын бохирдол, хөрсний шинжилгээ хийсэн. Хөрс, агаарын шинжилгээг Дархан-Уул аймгийн “Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв-д хяналтаар дахин ус, хөрсний шинжилгээ хийлгэсэн. Орчны агаарын шинжилгээг агаарын тоосжилтыг хэмждэг DustTrak DRX нэртэй багажаар, агаарын бохирдлыг MX-6 IBRID багажаар хэмжсэн.



Зураг 3. Агаарын
бохирдол хэмжсэн MX
IBRID багаж



Зураг 4. Агаар дахь тоосжилтыг хэмжсэн Dust Trak DRX багаж

Дүгнэлт

Манай компани нь үйл ажиллагаа нь тогтворжсон байнгын үйл ажиллагаатай, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан төлөвлөгөөт ажил үүргээ цаг тухай бүр хийж хэвшсэн, орон нутаг болоод иргэддээ нэр хүндтэй уурхайн нэг юм.

“Цохио толгой 2” шохойн чулууны ордоос 2025 онд 21.75 мян.м³ хөрс хуулж, 35.9 мян.тн шохойн чулуу, 20.26 мян.м³ дайрга гарган борлуулсан байна.

Манай компани нь “Цохио толгой – 2” уурхайд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 2025 оны эцсээр уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийт 8.9га талбайн гадаргуу өртөгдөж байна. Эндээс 0.3 га нь тухайн онд нэмж эвдрэлд орсон байна. Тус онд уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж багахан хэмжээний хөрс хуулж, шохойн чулуу болон дайвар бүтээгдэхүүнээр дайрга үйлдвэрлэсэн. Өрөмдлөг тэсэлгээний ажилд нийт **188 сая** төгрөгийн зардал гарсан.

2025 онд 0.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж дүйцүүлэн хамгаалах зардалд 3.000.000 төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 10.000.000 төгрөг зарцуулсан, 0,3га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж 300 ширхэг агч мод тарьж гүйцэтгэлээр 1.800.000 төгрөг тус тус зарцуулсан байна. Мөн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тусгай дансанд 4.007.650 төгрөгийг удирдах байгууллагаас өгөгдсөн хугацаанд байршуулсан.

2025 онд Манай компани Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан бүх ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, нөхөн сэргээлт болон байгаль хамгааллын ажлыг бүрэн гүйцэтгэлээ. Нийт 18.9 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөт зардлаа 236.8 хувиар давуулан биелүүлсэн нь манай байгууллага байгаль орчныг хамгаалах, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгааг харуулж байна. Ирэх жилүүдэд ч бид энэхүү бодлогоо хадгалж, орон нутаг, байгаль орчны тэнцвэрийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилт тавин ажиллана.